



Г.БАТТУЛГА
ХСИС-ийн Шүүхийн
шийдвэр гүйцэтгэлийн
сургуулийн Нийгмийн
ажлын тэнхимийн
эрхлэгч, хууль зүйн
магистр, хошууч

ЯЛТНУУДЫН ДУНД БҮРЭЛДЭН ТОГТСОН НИЙГЭМД ХАРШ ЗАН ҮЙЛ, ТҮҮНИЙ СӨРӨГ НӨЛӨӨ

Хураангуй: Гэмт хэрэгтнүүд ялангуяа ялтны дунд бүрэлдэн тогтсон нийгэмд харш соёл, зан үйл, түүний ойлголт, нийгэмд үзүүлэх хор нөлөө, урьдчилан сэргийлэх арга замыг судлах зорилго тавьсан болно.

Түлхүүр үг: Соёл, “өвөрмөц соёл”, шоронгийн “өвөрмөц соёл”, нийгэмд харш зан үйл,этгээд үг хэллэг, шорон судлал

Key words: Culture, subculture, prison subculture, antisocial behavior, slang, prison study/research

Үндсэн хэсэг

Хүн хүнтэйгээ харьцах харилцаа, ёс суртахуун, үзэл бодол, соёл нь нийгэм, хамт олон, гэр бүл, найз нөхдийн хүрээлэл, тэдний харилцан нөлөөллийн дунд төлөвшин тогтдог. Өөрөөр хэлбэл хувь хүний хүрээлэн буй орчин нь түүнийг төлөвшүүлж, хөгжүүлж, улмаар нийгэмд эзлэх байр сууриа олж авахад хүчтэй нөлөөлнө.

Гадны социологчид болон криминологчид нийгмийн жижиг бүлэг хэсгүүдийн дунд тогтсон үнэт зүйлс, хүсэл сонирхол, итгэл үнэмшил нь нийгмийн тодорхой хэсгийн “өвөрмөц соёл” бүрэлдэн тогтоход нөлөөлдөг гэж үздэг. Үүнийг Ангвар “Subculture” Орос хэлнээ “Субкультура” хэмээн тодорхойлсон байдаг ба барууны судлаачид шинжлэх ухааны үүднээс судлан тодорхой онол, сургааль /subculture theory/ боловсруулжээ. Харин криминологийн шинжлэх ухаанд уг онолыг авч ашиглан гэмт хэрэгтнүүдийн болон хорих ял эдэлж буй ялтнуудын дунд бүрэлдэн тогтсон, хэв шинж, нийгмийн бусад хэсэг бүлгүүдээс ялгагдах хэвшил болсон “өвөрмөц соёл” байдаг болохыг нотлон энэ талаар судалж иржээ.

Тэгвэл соёл гэж чухам юу вэ? Ямар хүчин зүйлсийн үр дүнд бүрэлддэг вэ? гэсэн асуулт зүй ёсоор урган гарна. Соёл нь “ард түмэн хойч үедээ хуримтлуулсан мэдлэгээ дамжуулан өвлүүлэх, түүндээ хойч үеэ сургах, хэвшүүлэх чадвартай холбогдсон хүний мэдлэг, итгэл үнэмшил, зан заншлын нийлбэр цогц”¹ бөгөөд соёлд “итгэл үнэмшил, нийгэмшлийн бүтэц, хэл, урлаг, шашин шүтлэг болон нийгмийн давхаргын бодит шинж чанар агуулагдаж эдгээр хүчин зүйлсийн

нөлөөгөөр тухайн нийгмийг тодорхойлохуйц нийтлэг үзэл санаа, үнэт зүйлс, зорилго, зан үйл бий болдог².

Германы криминологич Г.И.Шнайдер өвөрмөц соёлын талаар “нийгмийн оюун санаа, соёлын үнэт зүйлсээс тухайн хэсэг бүлгийг бүрдүүлэн бусдаас ялгаруулж буй оюун санааны болон бусад материаллаг үнэт зүйлсийн цогцыг өвөрмөц соёл хэмээн ойлгоно”³ гэсэн тайлбарыг хийжээ.

Криминологийн шинжлэх ухааны үүднээс авч үзвэл “өвөрмөц соёл” нь гэмт хэрэгтнүүдийн дунд төлөвшсөн зан чанар, орчин, нөхцлөөрөө нийгмийн бусад хэсэг бүлгээс ялгарах соёл, боловсрол, мэдлэг, зан заншил, амьдралын дадал хэвшлийн онцой ялгаа хэмээн ойлгож болох юм⁴.

Эдгээрээс үзвэл соёл гэсэн ерөнхий ухагдахуун гэмт хэрэгтнүүдийн дунд бүрэлдэн тогтсон “өвөрмөц соёл”-ын аль алинд нийтлэг хэв шинж байгаа болох нь харагдана. Гэмт этгээдүүдийн дунд бүрэлдэн тогтсон

“өвөрмөц соёл” нь тодорхой цаг хугацааны явцад үүсэн бий болж, өнгөрснөөс одоо, одоогоос ирээдүйд уламжлагдан хувьсаж байдаг зүй тогтолтой гэж үздэг. Энэ нь өөрийн гэсэн үнэт зүйл, хууль журам, зан заншил, амьдралын онцлог хэв маяг, хэм хэмжээ, дэглэм журам бүхий гэмт орчин буюу бидний хэлж заншсанаар гэмт хэргийн ертөнцийг бий болгож, тэр нь хувьсан өөрчлөгдөж байдаг.

Чухам яг хэдийд, ямар үед гэмт хэргийн ертөнц болон түүний уламжлал, ёс заншлууд төрөн бий болсныг хэлэхэд бэрх боловч ОХУ-ын эрдэмтэд түүхэн эх сурвалжуудад дүн шинжилгээ хийж гэмт хэргийн ертөнц Оросод 17-р зууны дунд үеэс бүрэлдэн бэхжсэн гэсэн дүгнэлтэнд хүрсэн байна⁵.

Улмаар ОХУ-ын судлаачид гэмт орчин үүсэн бий болсон нөхцөл байдал, гэмт зан үйл, хэвшил хэрхэн бүрэлдэж ирсэн талаарх түүхийн үйл явцыг үечлэн авч үзжээ. Ингэхдээ Хаант Орос улсаас орчин цаг хүртэл 7 үед ангилан гэмт хэргийн ертөнцийн уламжлал, ёс заншил, эрүүгийн ертөнцийн бичигдээгүй “хууль”, гэмт хэв маягийн амьдралын нууц хадгалах элементүүдийн нэг, түүний хамгийн хүчтэй хэв шинж болох гэмт хэрэгтнүүдийн этгээд үг хэллэг

¹ С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. 2007 он. УБ хот. 389 дэх тал

² Мөн тэнд. 390 дэх тал

³ Ганс Йоахим Шнайдер. Криминология. Москва. 1994. /Hans Joachim Schneider. Kriminologie. Berlin. New York. 1987/ с 284.

⁴ М.Цэнд. “Криминальная субкультура” буюу “ гэмт хэрэгтнүүдийн өвөрмөц зан үйлийн хэвшил”-ийн тухай. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал сэтгүүл. 2015.№01(13) 40 дэх тал.

⁵ Пенитенциарная криминология. Рязань. 2009 г. 160 ст

зэргийг⁶ түүхчлэн судалж, тэдэнтэй хэрхэн тэмцэх арга замаа боловсруулж ирсэн байна.

Тухайлбал Оросын эрдэмтэн В.Я. Лебедев гэмт хэрэгтнүүдийн нийгмийн эсрэг үзэл санаа, уламжлал, ёс заншлыг, Н.П. Мелешко тэдний нэгдэн нягтрах үзэгдлийг, У.У. Тайбакова халаасны хулгайч нарын онцлог, заншил уламжлал, шинэ залуу үеэ хэрхэн олж, тэднийг сурган дадлагажуулах арга барил, гэмт хэрэгтнүүдийн өвөрмөц этгээд хэллэг зэргийн талаар тухайлан судалжээ⁷.

Гаж үзэл бодол, хэм хэмжээ, үнэт зүйлсийн нөлөөллөөр гэмт хэргийн ертөнцийн оршин тогтнох нөхцөл бүрдэж улмаар гэмт бүлэглэлийн гишүүдийг нэгтгэж, холбож нягтруулдаг болохыг олон орны судлаачид тэмдэглэсэн байдаг.

ОХУ-н зарим судлаачид гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олон нийтээс тусгаарлан тодорхой хугацаагаар хорьж буй нь төрөөс хорих ялаар шийтгүүлэн шоронд хоригдож буй нийт ял эдлэгсэд буюу *албан бүлэг*, хорих ял эдлэх явцдаа хүсэл, сонирхол, хэрэгцээгээрээ өөр хоорондоо сайн дураараа нэгдсэн *албан бус бүлэг /хамт олон/* гэж

үндсэн хоёр хэсэгт хуваан авч үзсэн⁸. Өөрөөр хэлбэл хорих байгууллага нь гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн оршин амьдрах нийгмийн бичил орчин болдог байна.

Энэхүү бичил орчинд ял эдэлж буй хүмүүсийн дунд нийгмийн нийтлэг хэм хэмжээ, хууль тогтоомжын эсрэг үзэл санаа гүн гүнзгий оршин тогтнож байдаг. Ялангуяа олон жил ял шийтгэл эдэлж буй архаг гэмт хэрэгтнүүд буюу нөлөө бүхий ялтнуудын зүгээс бусад ялтнууд, тэр дундаа залуу ялтнуудын үзэл санаанд нөлөөлж өөрсдийн мөрдлөг хэм хэмжээг дагах, хорих байгууллагын зүгээс тавьдаг хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, өөрсдийгөө хүндлүүлэх, аялдан дагалдах, гэмт хэргийн замыг сонгох, ялтны бүлэглэлд татан оруулах чиглэгдсэн үйл ажиллагааг идэвхтэй явуулдаг.

АНУ-ын судлаачид Дэвид Пируз, Меган Мичел нар ялтны гэмт бүлэглэл гэдгийг "өөрийн хүсэл сонирхол, үзэл бодол эсвэл албадлагаар нэгдсэн, тогтсон дүрэм журам зохион байгуулалт бүхий гэмт санаа бодлоо хэрэгжүүлэхэд чиглэсэн ялтнуудын нэгж юм"⁹ гэж

⁶ Пенитенциарная криминология. Рязань. 2009 г. 161 ст

⁷ М.Цэнд. “Криминальная субкультура” буюу “ гэмт хэрэгтнүүдийн өвөрмөц зан үйлийн хэвшил”-ийн тухай. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал сэтгүүл. 2015.№01(13) 41 дэх тал.

⁸ И.А. Уванов., Введение в пенитенциарную криминологию. Москва 2007 г. Стр 15.

⁹ David Pyrooz, Meghan M. Mitchell. *Prison Gangs and Subculture* (Oxford Bibliographies) 2015.<http://www.oxfordbibliographies.com/view/document/obo-9780195396607/obo-9780195396607-0168.xml#obo-9780195396607-0168-div1-0003>

тодорхойлсон байна. Мэдээж ялтнуудын зарим хэсэг нь дээрх бүлэглэлд нэгдэж гэмт хэргийн замд эргэлт буцалтгүй ордог бол ихэнх хэсэг нь үүний гадна үлддэг. Гэсэн хэдийч ялтны доторхи бүлэглэл бэхжих, цуллаг байдал үүсэх нь олон төрлийн сөрөг үр дагаварыг үүсгэдэг бөгөөд тэдний дунд бүрэлдэн тогтсон “өвөрмөц соёл”, нууц, далд харилцааны хэв шинж нь бусад ялтнуудад нийгэмд харш зан үйл төлөвшихөд ихээхэн нөлөө үзүүлдэг байна.

Иймд ялтнуудын дундах албан бус бүлэглэл, шоронгийн өвөрмөц соёл /prison subculture/, тэдний хоорондын харилцан хамаарал, ялтнуудын амьдралын онцгой хэв маяг, нийгмийн амьдралд үзүүлж буй сөрөг нөлөө, учруулж буй хор уршиг зэргийг нарийвчлан судалж түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх арга замаа боловсруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Өнөөдөр нийгэмд болон судлаачдын дунд ял эдэлсэн хүмүүс засарч хүмүүжих бус харин гэмт хэрэг үйлдэх арга барилд суралцаад, шоронгийн амьдрал, соёлд дасан зохицоод гардаг гэсэн шүүмжлэл гарах болсныг үгүйсгэх аргагүй билээ. Олон улсын байгууллагын сүүлийн үед хийсэн судалгаагаар улсын хэмжээнд ял эдлэж буй нийт ялтнуудын 50.2% буюу талаас илүү хувь нь дахин гэмт

хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн байна.¹⁰

Үүнээс үзэхэд уг асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй нарийвчлан судалж, зүй тогтлыг нь илрүүлэх, улмаар цаашид хэрхэн тэмцэх арга замаа боловсруулах хэрэгцээ, шаардлага бий болжээ.

Гадны зарим орны практикаас харахад гэмт бүлэглэл, ялангуяа хорих байгууллага дахь ялтнуудын бүлэглэл, тогтсон хэв маяг, зохион байгуулалт, үнэт зүйлс, хэм хэмжээ, ёс суртахуун зэргийг тусгайлан судалж энэ талаар ихээхэн туршлага хуримтлуулж байна. Тухайлбал Английн Оксфордын их сургуулийн дэргэдэх Шорон судлалын хүрээлэн, АНУ-ын Гэмт бүлэглэл судлалын үндэсний төв, Станфордын их сургуулийн дэргэдэх шорон судлалын төв зэргийн дурдаж болох бөгөөд манай хөнш ОХУ-д шорон судлал өндөр хөгжсөн талаар дээр дурдсан.

Гэмт хэргийн ертөнцийн соёл, “ёс суртахууны” үндсийг бэхжүүлэх зорилгоор “шоронгийн хууль” гэгчийг сурталчлах, дэлгэрүүлэх талаар гэмт хэргийн ертөнцийн нөлөө бүхий этгээдүүд ихээхэн идэвхтэй ажилладаг бөгөөд ихэвчлэн залуучууд болон насан хүрээгүй хүмүүсийг дунд уг ажиллагаагаа зохион байгуулдаг байна.

¹⁰ Present conditions of human rights in Mongolian prison. Survey report. Caritas Czech Republic. Ulaanbaatar. 2014. p 176

Хорих ангид ялтны дунд оршин байдаг “шоронгийн хууль” (ялтнуудын дунд тогтсон үнэт зүйлс, итгэл үнэмшил зэрэг өвөрмөц байдлын цогц) гэгч нь гэмт хэрэгтнүүд болон ялтнуудын дунд бүрэлдсэн өвөрмөц соёлтой холбодон хамт оршин тогтнодог¹¹ гэж үздэг.

Ялтнуудын харилцааны, нууцлалын болон ертөнцийг үзэх үзлийн илэрхийлэл болсон этгээд үг хэллэг нь криминологийн ач холбогдлоороо чухал байр суурийг эзэлдэг. Үүний тусламжтайгаар ялтнуудын дунд тогтсон зан үйл, дүрэм, хэм хэмжээг уламжлан дамжуулж бэхжүүлж байдаг ба этгээд үг хэллэг нь түүнийг хэрэглэгчдийг нэгтгэн нягтруулж, нийтлэг байдал, нэгдмэл ахан дүүс гэсэн ойлголтыг төрүүлдэг ажээ. Этгээд үг хэллэг хэрэглэж эхлэх үед өдөр тутмын ярианд нэвтрэн шингэж улмаар тухайн этгээдийн ухамсарт нөлөөлөн, үзэл бодол, үнэт зүйлст өөрчлөлт орж, бие хүний үзэл суртал, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлэн ертөнцийг үзэх гаж үзэл бодлыг маш худтайгаар бүрдүүлдэг байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Нийгэм, сэтгэл зүйн

хэлтсээс явуулсан судалгаанаас үзэхэд¹² судалгаанд хамрагдсан ялтнуудын 91.7 хувь нь ямар нэг байдлаар этгээд үг хэллэг хэрэглэдэг гэснээс үзвэл тэдний хоорондын харилцааны өвөрмөц хэрэгсэл гэдэг нь харагдана.

Харин манай оронд энэ талаар хийгдсэн судалгаа байхгүй бөгөөд хорих ангид үйлдэгддэг пенитенциар гэмт явдалтай тэмцэх, түүний шалтгаан, нөхцлийг тогтоон, гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга замыг боловсруулахад өнөөгийн хорих ангийн, төрөл дэглэмийн ялгаа, ял эдлэгсдийн онцлог, тэдний хоорондын харилцаа, тогтсон “өвөрмөц соёл”, этгээд үг хэллэг, нийгмийн амьдралд үзүүлж буй сөрөг нөлөө зэргийг харгалцан судлан авч үзэх шаардлагатай юм. Тухайлбал ялтны доторх албан бус бүлэглэл болох “гал хам” бүлэглэлүүдийн бүтэц зохион байгуулалт, түүний шатлан захирах ёс, тогтсон хэм хэмжээ, “дархлагдсан ялтнууд” болон нөлөө бүхий ялтнуудын зан төлөв, биеэ авч яваа байдал, яриа өгүүлэл, зэргийг онцгойлон судлан авч үзэх чухал билээ.

Дүгнэлт

Дээрхээс дүгнэн үзвэл бусад улс оронд болон манай улсад ч гэмт хэрэгтнүүдийн дунд өвөрмөц соёл, тогтолцоо, бүрэлдэн бий болж гэмт

¹¹Courtney A. Waid, Theoretical Studies of the Prison Subculture: Contemporary Explanations for Female Inmates. Florida State University. http://sociologyindex.com/prison_subculture.htm

хэргийн ертөнцийн уламжлал, ёс заншил, эрүүгийн ертөнцийн бичигдээгүй “хууль” оршин тогтнож байна. Манай улсын хувьд ялтнуудын дундах албан бус бүлэглэл, шоронгийн өвөрмөц соёл /prison subculture/, тэдний хоорондын харилцаа, этгээд үг хэллэг, амьдралын онцгой хэв маяг, нийгмийн амьдралд үзүүлж буй сөрөг нөлөө, учруулж буй хор уршиг зэргийг тусгайлан судалж түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга зам боловсруулах хэрэгцээ, шаардлага хэдийнээ бий болжээ.

Ялангуяа ялтан, хоригдогсдын үзэл санаа, хүсэл сонирхол, тэдний хүрээлэн буй нийгмийн бичил орчин дахь нууцлагдмал хэв маяг, “шоронгийн өвөрмөц соёл” /prison subculture/, ялтнуудын албан бус бүлэг, түүний зохион байгуулалт, тэдний санаа сэтгэлийг хэрхэн удирдан чиглүүлэх талаар судлан ойлгохгүйгээр тэднийг “дахин нийгэмшүүлэх”, гэмт санаа бодлоос нь татгалзуулах, нийгмийн нийтлэг хэм хэмжээ, хууль дүрмийг сахин биелүүлдэг иргэн болгон төлөвшүүлэхэд хүндрэл учирсаар байх болно. Иймд бид энэ чиглэлээр шинжлэх ухааны мэдлэгт суурилсан өргөн хүрээтэй судалгаа явуулах шаардлагатай бөгөөд илтгэлийн

хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хөндөн бичиж буй сэдвийн хүрээнд криминологи, социологи, сэтгэл судлалын болон бусад шинжлэх ухааны мэдлэгт суурилсан олон төрлийн судалгааны ажил хийх түүндээ энэ чиглэлийн судлаач, эрдэмтдийг татан оролцуулах.

2. Шорон судлалын /prison study/ төвийг шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын эрдэмтэн, судлаач, профессор, багш нарын оролцоотойгоор ХСИС-ийг түшиглэн байгуулах. Энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, гадны ижил чиг үүрэг бүхий судалгааны байгууллагатай хамтран ажиллах, тэдний туршлагыг судлах.

3. Хорих ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхдээ ялтныг хооронд холих, ёс суртахууны, зан төлөвийн эвдрэлд оруулан “шоронжуулж” /prisonization/ буй байдлыг даруй өөрчлөх. Анх удаа гэмт хэрэг үйлдэн хорих ялаар шийтгүүлсэн ялтныг давтан гэмт хэрэг үйлдсэн ялтнаас, засарч хүмүүжиж буй ялтныг засрал хүмүүжил олоогүй ялтнаас тусад нь ял эдлүүлэхэд анхаарч ялтныг хэд хэдэн зэрэглэлд ангилан ял эдлүүлэх зэрэг саналуудыг судлаачийн зүгээс дэвшүүлж байна.

¹² ШШГЕГ-ын Нийгэм, сэтгэл зүйн хэлтсээс 2013 онд явуулсан судалгааны тайлан.